



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар АА36

Булган сум

**Бүгд Найрамдах Солонгос Улсын Хусо  
Их сургуулийн оюутнуудын дотуур байрны  
төлбөрт хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Хусо Их сургуультай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр аймгийн Засаг даргын нэрэмжит 100 хувийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах шалгуурыг хангаж, хэлний бэлтгэлийн хөтөлбөрт элсэн суралцаж буй оюутнуудын дотуур байрны төлбөрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дотуур байрны төлбөрийн тэтгэлэг олгоход шаардлагатай 19,238,418 (арван есөн сая хоёр зуун гучин найман мянга дөрвөн зуун арван найм) төгрөг, гадаад гуйвуулгын төлбөрт 80,000 (наян мянга) төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР